


# МӨНГӨНИЙ ТОЙМ

/2015 оны 1 дүгээр сар/



## МӨНГӨ, САНХҮҮГИЙН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

	2014								2015		
	12-р сар	3-р сар	6-р сар	7-р сар	8-р сар	9-р сар	10-р сар	11-р сар	12-р сар	1-р сар	
<b>Инфляци</b>											
Улаанбаатар хотын инфляци											
сарын		1.7	0.5	0.5	0.6	0.7	1.0	0.8	0.6	0.6	0.5
оны эхнээс		11.2	3.3	6.0	6.6	7.4	8.5	9.4	10.1	10.7	0.5
жилийн		11.2	11.9	15.1	15.4	13.6	13.6	12.7	11.9	10.7	9.3
Суурь инфляци											
сарын		1.3	0.2	0.6	2.2	2.4	1.3	1.5	0.8	0.4	0.4
оны эхнээс		12.1	1.2	3.3	5.6	8.1	9.6	11.3	12.2	12.6	0.4
жилийн		12.1	12.6	15.8	17.9	15.6	15.5	14.1	13.6	12.6	12.3
Улсын инфляци											
сарын		0.7	0.8	0.5	0.4	0.4	0.7	0.8	0.7	0.8	0.7
оны эхнээс		11.9	3.5	6.7	7.2	7.7	8.5	9.3	10.1	11.0	0.7
жилийн		11.9	12.4	14.6	14.9	13.7	13.0	12.1	11.5	11.0	9.8
<b>M2 мөнгө, тэрбум төгрөгөөр</b>											
сарын өөрчлөлт, %		9 454.9	9 949.4	10 107.0	10 078.2	10 136.0	10 074.3	9 973.3	9 928.1	10 635.8	10 314.6
жилийн өөрчлөлт, %		3.9	1.0	-1.3	-0.3	0.6	-0.6	-1.0	-0.5	7.1	-3.0
<b>Бараг мөнгө, тэрбум төгрөгөөр</b>											
сарын өөрчлөлт, %		7 361.7	8 212.1	8 244.9	8 379.8	8 261.3	8 238.0	8 221.5	8 238.4	8 819.1	8 735.6
жилийн өөрчлөлт, %		1.2	1.5	-2.0	1.6	-1.4	-0.3	-0.2	0.2	7.0	-0.9
<b>Гүйлгээнд байгаа бэлэн мөнгө, тэрбум төгрөгөөр</b>											
сарын өөрчлөлт, %		841.1	801.2	860.0	859.6	880.1	827.3	809.6	769.0	809.7	732.4
жилийн өөрчлөлт, %		4.6	5.9	-0.3	-0.1	2.4	-6.0	-2.1	-5.0	5.3	-9.5
<b>Нөөц мөнгө, тэрбум төгрөгөөр</b>											
сарын өөрчлөлт, %		3 335.5	3 127.5	2 882.2	2 905.1	2 814.8	2 826.5	2 707.7	2 679.5	3 426.5	2 858.7
жилийн өөрчлөлт, %		18.1	-0.1	-4.2	0.8	-3.1	0.4	-4.2	-1.0	27.9	-16.6
<b>Зээлийн үлдэгдэл, тэрбум төгрөгөөр</b>											
сарын өөрчлөлт, %		54.0	26.7	-17.9	-6.4	8.2	-4.0	2.4	-5.1	2.7	-3.3
жилийн өөрчлөлт, %		10 764.2	11 380.9	12 302.1	12 225.4	12 338.4	12 611.5	12 833.5	12 648.4	12 502.5	12 088.8
<b>Чанаргүй зээл/Нийт зээл, хувиар</b>											
Чанаргүй зээл/Нийт зээл, хувиар (Хадгаламж, Анод, Зоос-ыг хассанаар)		5.26	5.22	4.61	4.91	5.02	4.68	4.72	4.90	5.00	5.45
<b>Хуу</b>											
Хадгаламжийн ЖДХ		2.48	2.57	2.72	3.00	3.16	2.84	2.91	3.06	3.10	3.51
Зээлийн ЖДХ*		12.1	12.2	12.2	12.2	12.2	12.3	12.6	12.7	12.5	12.7
Монголбанкны УТХ зээлийг оруулсан ЖДХ*		17.4	19.7	18.8	19.2	19.6	18.3	18.9	18.6	19.5	20.0
Ипотекийн зээлийн ЖДХ		14.9	17.8	17.3	17.5	17.6	16.3	16.9	17.1	16.9	16.9
ТБҮЦ-ны ЖДХ		9.90	9.90	10.5	10.7	10.5	10.6	10.4	10.3	9.9	10.2
Бодлогын хүү		10.5	10.6	10.6	10.6	11.8	12.1	12.1	12.1	12.1	12.3
БХЗ-ын ЖДХ		10.5	10.5	10.5	12.0	12.0	12.0	12.0	12.0	12.0	13.0
		8.9	9.4	10.4	10.8	12.4	12.4	12.7	12.4	12.2	12.6

\* Төгрөгийн зээлийн жижигсэн дундаж хүү

## Инфляци

Хэрэглээний үнийн улсын индекс 2015 оны 1 дүгээр сарын эцэст өмнөх сараас 0.7 хувь, өмнөх оны мөн үеэс 9.8 хувь, Улаанбаатар хотын хэрэглээний үнийн индекс өмнөх сараас 0.5 хувь, өмнөх оны мөн үеэс 9.3 хувиар тус тус өслөө. Суурь инфляци сарын 0.4 хувь, жилийн 12.3 хувь байв.

Тухайн сард хүнсний ногооны үнэ 4.1 хувь, махны үнэ 0.9 хувь, сүү, сүүн бүтээгдэхүүн, өндөгний үнэ 0.2 хувиар өсч харин гурилын үнэ 0.3 хувиар буурснаар (үүнд бялууны үнэ 8 хувиар буурсан нь нөлөөтэй) хүнсний барааны бүлгийн үнэ 0.5 хувиар өссөн байна. Харин хүнснээс бусад бараа, үйлчилгээний үнэ 0.4 хувиар өссөн нь тээврийн бүлгийн үнэ 1.7 хувь (үүнд зогсоолын төлбөр 33.3 хувиар өссөн нь гол нөлөөтэй), хувцас, бөс бараа 0.4 хувиар өссөнтэй холбоотой байна. Харин холбоо, шуудангийн үйлчилгээний үнэ 0.2 хувиар буурсан байна.

Тухайн сард нийт хэрэглээний сагсыг бүрдүүлж буй 329 бараа үйлчилгээнээс 55 бараа үйлчилгээний үнэ нь өсч, 5 бараа үйлчилгээнийх буурсан байна.




**Жилийн инфляцийн** 13.2 хувийг хүнсний бараа, согтууруулах бус ундаа, 86.8 хувийг хүнснээс бусад барааны бүлгийн үнийн өсөлт бүрдүүлсэн байна. Орон сууц, ус, цахилгаан, түлшний бүлгийн үнэ 22.2 хувь (жилийн өсөлтийн 31.8 хувь), боловсрол 17.7 хувь (жилийн өсөлтийн 13.2 хувь), хувцас, бөс бараа, гутал 9.0 хувь (жилийн өсөлтийн 12.7 хувь), тээвэр 8.1 хувь (жилийн өсөлтийн 9.9 хувь), согтууруулах ундаа, тамхи 10.0 хувь (жилийн өсөлтийн 5.0 хувь), эм тариа, эмнэлгийн үйлчилгээ 11.4 хувь (жилийн өсөлтийн 3.6 хувь), гэр ахуйн тавилга, бараа 8.5 хувь (жилийн өсөлтийн 3.0 хувь), бусад бараа үйлчилгээний бүлэг 7.6 хувиар (жилийн өсөлтийн 3.0 хувь) тус тус өссөн байна.

Хүнсний барааны бүлгийн үнэ жилийн 1.1 хувийн өсөлтийн 1.2 нэгж хувийг талх, гурил, будаа, 0.3 нэгж хувийг өндөг, сүү, сүүн бүтээгдэхүүн, 0.2 нэгж хувийг хүнсний ногоо, 0.1 нэгж хувийг жимс, жимсгэнэ, -1.0 нэгж хувийг мах, махан бүтээгдэхүүний үнийн өсөлт бүрдүүлсэн байна.

## Мөнгөний нийлүүлэлт


Мөнгөний нийлүүлэлт өмнөх сараас 3.0 хувиар буурч, өмнөх оны мөн үеэс 2.9 хувиар өсч 10314.6 тэрбум төгрөгт хүрчээ.

Мөнгөний нийлүүлэлтийн 52.0 хувийг төгрөгийн хадгаламж, 21.3 хувийг валютын хадгаламж, 11.4 хувийг валютын харилцах, 10.8 хувийг төгрөгийн харилцах, 4.5 хувийг хадгаламжийн байгууллагуудаас гадуурх мөнгө эзэлж байна.



Тайлант сард төгрөгийн хадгаламжийн жилийн өсөлтийн хурд өмнөх сарынхаас 2.1 нэгж хувь, төгрөгийн харилцахынх 4.6 нэгж хувь, хадгаламжийн байгууллагуудаас гадуурх мөнгөнийх 10.1 нэгж хувь, гадаад валютын хадгаламжийнх 18.3 нэгж хувь, гадаад валютын харилцахынх 48.7 нэгж хувиар тус тус буурсан байна.

Мөнгөний үзүүлэлтүүдийн сарын өөрчлөлтийг авч үзвэл гадаад валютын хадгаламж 226.0 тэрбум төгрөгөөр өссөн бол хадгаламжийн байгууллагуудаас гадуурх мөнгө 30.5 тэрбум төгрөг, төгрөгийн хадгаламж 45.7 тэрбум төгрөг, төгрөгийн харилцах 207.2 тэрбум төгрөг, гадаад валютын харилцах 263.8 тэрбум төгрөгөөр буурчээ.



Тайлант сарын мөнгөний нийлүүлэлтийн 2.9 хувийн жилийн өсөлтийн 4.0 нэгж хувийг төгрөгийн хадгаламж, 2.9 нэгж хувийг гадаад валютын хадгаламж, -0.1 нэгж хувийг гадаад валютын харилцах, -1.5 нэгж хувийг хадгаламжийн байгууллагуудаас гадуурх мөнгө, -2.3 нэгж хувийг төгрөгийн харилцах тус тус бүрдүүлсэн байна.

### Хадгаламж

Нийт хадгаламж өмнөх сараас 2.4 хувь буюу 180.3 тэрбум төгрөг, өнгөрсөн оны мөн үеэс 10.0 хувь буюу 688.6 тэрбум төгрөгөөр өсч 7560.3 тэрбум төгрөг болов.



Аж ахуйн нэгж, байгууллагуудын төгрөгийн хадгаламж өмнөх сараас 0.3 хувь буюу 4.3 тэрбум төгрөгөөр буурч, өнгөрсөн оны мөн үеэс 28.6 хувь буюу 348.7 тэрбум төгрөгөөр өсч 1567.5 тэрбум төгрөг болсон бол иргэдийн төгрөгийн хадгаламж өмнөх сараас 1.1 хувь буюу 41.4 тэрбум төгрөгөөр буурч, өнгөрсөн оны мөн үеэс 1.4 хувь буюу 51.6 тэрбум төгрөгөөр өсч 3797.0 тэрбум төгрөгт хүрчээ. Гадаад валютын хадгаламж өмнөх сараас 11.5 хувь буюу 226.0 тэрбум төгрөг, өнгөрсөн оны мөн үеэс 15.1 хувь буюу 288.4 тэрбум төгрөгөөр өсч 2195.8 тэрбум төгрөг болжээ.




Нийт хадгаламжийн 71.0 хувь нь төгрөгийн, 29.0 хувь нь валютын хадгаламж байгаа бөгөөд төгрөгийн хадгаламжийн нийт хадгаламжинд эзлэх хувь өмнөх оны мөн үеэс 1.3 нэгж хувиар буурсан байна.

### Гадаад, дотоод цэвэр актив


Гадаад цэвэр актив өмнөх сараас 25.8 хувь, өмнөх оны мөн үеэс 1.8 дахин буурснаар -2140.3 тэрбум төгрөгт, дотоод цэвэр актив

өмнөх сараас 8.5 хувь, өмнөх оны мөн үеэс 7.6 хувиар буурч 8174.3 тэрбум төгрөг болов.



### Нөөц мөнгө

Нөөц мөнгө өмнөх сараас 16.6 хувь, өмнөх оны мөн үеэс 3.3 хувиар буурч 2858.7 тэрбум төгрөгт хүрэв. Тайлант сард хадгаламжийн байгууллагуудаас гадуурх мөнгө 6.1 хувь буюу 30.5 тэрбум төгрөг, банкуудын касс 15.2 хувь буюу 46.8 тэрбум төгрөг, Төв банк дахь харилцах, хадгаламж 18.7 хувь буюу 490.5 тэрбум төгрөгөөр буурсан байна.



Банкуудын Төв банк дахь харилцах, хадгаламжийн нөөц мөнгөнд эзлэх хувь өмнөх оны мөн үеэс 4.6 нэгж хувиар өсч 74.5

хувь, банкуудын кассын эзлэх хувь 0.1 нэгж хувиар буурч 9.1 хувь, хадгаламжийн байгууллагуудаас гадуурх мөнгөнийх 4.5 нэгж хувиар буурч 16.4 хувь болсон байна.

## ЗЭЭЛ


*Хадгаламжийн байгууллагуудын зээлийн үлдэгдлийн жилийн өсөлтийн хурд оны эхнээс саарсаар байна. Тухайлбал, тайлант сард өмнөх сараас 6.3 нэгж хувиар буурчээ.*

Хадгаламжийн байгууллагуудаас<sup>1</sup> олгосон зээл өмнөх сарынхаас 3.3 хувь буюу 413.7 тэрбум төгрөгөөр буурч, өнгөрсөн оны мөн үеэс 9.8 хувь буюу 1079.1 тэрбум төгрөгөөр өсч 12.1 их наяд төгрөгт хүрсэн байна. Хадгаламжийн байгууллагуудаас хувийн хэвшилд олгосон зээл өмнөх сараас 0.8 хувь буюу 52.0 тэрбум төгрөгөөр буурсан бол өнгөрсөн оны мөн үеэс 9.5 хувь буюу 573.3 тэрбум төгрөгөөр өсч 6601.2 тэрбум төгрөгт, иргэдэд олгосон зээл өмнөх сараас 6.1 хувь буюу 348.0 тэрбум төгрөгөөр буурч, өнгөрсөн оны мөн үеэс 10.5 хувь буюу 509.6 тэрбум төгрөгөөр өсч 5362.5 тэрбум төгрөгт хүрсэн байна.

<sup>1</sup>Хадгаламжийн байгууллагад арилжааны банкуудаас гадна мөнгөний нийлүүлэлтийн тооцоонд ордог харилцах, хадгаламж хэлбэрээр бусдаас хөрөнгө



Нийт зээлийг өмчлөгчөөр нь авч үзвэл 54.6 хувь нь хувийн хэвшил, 44.4 хувь нь иргэд, 1.0 хувь нь улсын байгууллага, 0.1 хувь нь бусад байгууллагад олгосон зээл байна.



Нийт зээлийн үлдэгдлийн 91.9 хувийг хэвийн зээл, 2.6 хувийг хугацаа хэтэрсэн зээл, 5.4 хувийг чанаргүй зээл тус тус эзлэв. Нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн хувь өнгөрсөн оны мөн үеийнхээс 0.2 нэгж хувиар өссөн байна. Татан буугдсан банкуудын


татан төвлөрүүлдэг санхүүгийн байгууллага (Хадгаламж, зээлийн хоршоо) хамрагдана.

мэдээллийг хасч тооцвол нийт зээлд эзлэх чанаргүй зээл 3.5 хувьтай байна.

## Картын зээл

Иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудын банкны картын зээлийн үлдэгдэл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 2.1 хувийг бүрдүүлж байна.

Картын зээл тайлант сард 257.7 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 0.9 хувиар буюу 2.3 тэрбум төгрөгөөр өсчээ. Картын зээлийн дийлэнхийг иргэдэд олгосон байгаа бөгөөд иргэдийн картын зээл өмнөх сараас 1.9 хувиар буюу 5.1 тэрбум төгрөгөөр буурсан байна.



Картын зээлийн 95.3 хувь нь хэвийн, 1.7 хувь нь хугацаа хэтэрсэн, 3 хувь нь чанаргүй гэж ангилагджээ. Картын зээлийн 94.4 хувь нь төгрөгөөр, 5.6 хувь нь валютаар олгогдсон байна

<sup>2</sup> Банкуудын тухайн сард олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү нь Монголбанкны үнэ тогтворжуулах хөтөлбөрийн (ҮТХ) зээлийг оруулахгүй тооцсон хүү болно. Харин ҮТХ-ийн зээлийг оруулан тооцвол

## Хүү

Төв банкны үнэт цаасны жигнэсэн дундаж хүү 2015 оны 1 дүгээр сард өнгөрсөн оны мөн үеэс 1.8 нэгж хувиар өсч жилийн 12.30 хувь болов. Банкуудын тухайн сард олгосон төгрөгийн зээлийн жигнэсэн дундаж хүү өнгөрсөн оны мөн үеэс 1.1 нэгж хувиар өсч жилийн 20.0<sup>2</sup> хувь, гадаад валютынх өмнөх оны мөн үеэс 1.2 нэгж хувиар өсч жилийн 13.6 хувь болжээ.




Харилцах, хадгаламжийн жигнэсэн дундаж хүү өөрчлөлт багатай байгаа бөгөөд төгрөгийн харилцахын жигнэсэн дундаж хүү жилийн 3.0 хувь, валютынх жилийн 1.6 хувьтай байна. Төгрөгийн хадгаламжийн жигнэсэн дундаж хүү жилийн 12.7 хувь, валютын хадгаламжийн жигнэсэн дундаж хүү жилийн 5.9 хувь болов.

төгрөгийн жигнэсэн дундаж хүү тайлант сард 16.9 хувь байна.

### Мөнгөний зах

2015 оны 1 дүгээр сард банк хоорондын захын арилжаагаар нийт 578.2 тэрбум төгрөгийн гүйлгээ хийгджээ. Эдгээр арилжааны жигнэсэн дундаж хүү жилийн 12.6 хувь байна.



2015 оны 1 сарын 7-ны өдрөөс 2015 оны 2 дүгээр сарын 3-ны өдрийн хугацаанд банкууд төгрөгийн заавал байлгах нөөцөд 890.8 тэрбум төгрөг, валютын заавал байлгах нөөцөд 414.0 тэрбум төгрөг байлгах шаардлагыг хангаж ажиллав. Банкууд төгрөгийн заавал байлгах нөөцөд 921.3 тэрбум төгрөг, валютын нөөцөд 1554.5 тэрбум төгрөг тус тус төвлөрүүлсэн байна.

### Валютын ханш

Төгрөгийн ам. доллартай харьцах ханш 2015 оны 1 дүгээр сарын эцэст 1944.78 төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 221.6 төгрөгөөр суларсан байна. Тайлант сард төгрөгийн ам. доллартай харьцах дундаж ханш 1932.7 төгрөг байв.

